

АХМАД НАСТАН, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭН, ХҮҮХДИЙН ТӨЛӨӨ ЗОРИУЛЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ, ТӨСӨЛ, ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.9.2 дахь заалтад заасан ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийн төлөө зориулж хэрэгжүүлсэн бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаа болон хандив, санхүүгийн дэмжлэг олгосон аж ахуйн нэгж, байгууллагад татварын хөнгөлөлт эдлүүлэхэд энэхүү шаардлагыг баримтална.

1.2 Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийн төлөө зориулж хэрэгжүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгө оруулалт, хандив, санхүүгийн дэмжлэг авсан бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаанд дараах хууль, журам, стандартыг мөрдлөг болгоно:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай НҮБ-ын конвенц;
- Хүүхэд хамгааллын тухай хууль;
- Хүүхдийн эрхийн тухай хууль;
- Гэр бүлийн хүчирхийллийн тухай хууль;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль;
- Нийгмийн халамжийн тухай хууль;
- Ахмад настны тухай хууль;
- Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээний журам;
- Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ үзүүлэгчид тавигдах ерөнхий шаардлага MNS5852:2017;
- Хүүхдийн зуслангийн үйл ажиллагаа Ерөнхий шаардлага MNS5633:2023;
- Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчны стандарт MNS6055:2009;
- Ахмад настны асрамжийн үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага, стандарт MNS5823:2016;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний асрамжийн үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага, стандарт MNS5897:2016;
- Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар, стандарт MNS6056:2009;
- Хүүхдийн тоглоомын талбайн ерөнхий шаардлага MNS6751:2019.

1.3. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.9, 22.9.2 22.11-д заасан Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийн төлөө зориулж хэрэгжүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгө оруулалт, хандив, санхүүгийн дэмжлэг авсан бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаанд энэхүү шаардлага тавигдана.

1.4. Улсын төсвийн хөрөнгө оруулалт, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд энэхүү зохицуулалт хамаарахгүй.

Хоёр. Зорилго, хамрах хүрээ

2.1 Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийн асрамжийн үйлчилгээ, тэдгээрийн эрхийг хангах, хамгаалах, хүүхдийн тоглоомын талбай, зуслан, цэцэрлэгт хүрээлэн барьж байгуулах, сэргээн засварлах, тохижуулах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тохируулгат орчин бүрдүүлэх үйл ажиллагаанд татварын хөнгөлөлт үзүүлэхэд оршино.

2.2 Монгол Улсын нутаг дэвсгэрт ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийн эрхийг хангах, хамгаалах чиглэлээр бүтээн байгуулалт, төсөл үйл ажиллагаа хэрэгжүүлсэн болон хандив, санхүүгийн дэмжлэг үзүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагад хамаарна.

Гурав. Нэр томъёоны тодорхойлолт

3.1. **“хүүхэд”** гэж төрсөн цагаас нь эхлэн 18 нас хүрээгүй хүн бүрийг¹.

3.2. **“хөгжлийн бэрхшээлтэй хүн”** гэж бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг;²

3.3. **“ахмад настан”** гэж Ахмад настны тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан иргэнийг;³

3.4. **“төрөлжсөн асрамжийн үйлчилгээ”** гэж асран хамгаалах, харгалзан дэмжих төрөл, садангүй бөгөөд бие даан амьдрах чадваргүй, ганц бие, байнгын эмчилгээ, асаргаа шаардагдах ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэн, түүнчлэн эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг байрлуулан хоол, хувцас, эмнэлэг, соёл, ахуй, сэтгэл зүй, асаргаа сувилахуйн үйлчилгээ үзүүлэх, тэдний амьдралын хэвийн нөхцөлийг бүрдүүлэх, хууль ёсны эрх ашгийг нь хууль тогтоомжид заасны дагуу хамгаалах үйл ажиллагааг;⁴

3.5. **“хүүхдийн зуслан”** гэж үзэсгэлэнт байгаль, цэвэр орчинд байрласан, олон улс, үндэстний хүүхэд, өсвөр үе, залуучуудын эрхийг дээдэлсэн, тэдний амрах, хөгжих, оролцох, чөлөөт цагаа зөв зохистой өнгөрүүлэх хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хүүхдэд ээлтэй, аюулгүй ногоон орчныг бүрдүүлсэн үйлчилгээний байгууллага;⁵

3.6. **“хүүхдийн тоглоомын талбай”** гэж хүүхэд бие бялдраа хөгжүүлэх, чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэх, тоглох зориулалт бүхий талбай;⁶

3.7. **“хөрөнгө оруулалт”** гэж Монгол Улсын нутаг дэвсгэрт ашгийн төлөө үйл ажиллагаа явуулах этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгөд оруулсан, санхүүгийн тайланд туссан биет болон биет бус хөрөнгийг;⁷

3.8. **“хандив”** гэж тодорхой зориулалтаар, үнэ төлбөргүй, эсхүл нийтэд санал болгож байгаа хөнгөлөлтөөс илүү хөнгөлөлттэй үнээр санхүүгийн эх үүсвэр, эд хөрөнгө шилжүүлэх болон үйлчилгээ үзүүлэхийг;⁸

3.9. **“санхүүгийн дэмжлэг”** гэж тухайн байгууллагын үйл ажиллагааг дэмжих зорилгоор олгох мөнгөн хөрөнгийг;⁹

3.10. **“тохирох хэрэглэгдэхүүн”** гэж хөгжлийн бэрхшээлтэй хүн бусдын адил хүний үндсэн эрх, эрх чөлөөг тэгш эдлэхэд зориулсан нэн хэрэгцээтэй тоног төхөөрөмж, материал, хэрэгсэл, программ хангамж, орчин нөхцөл, үйлчилгээг;¹⁰

3.11. **“түгээмэл загвар”** гэж нэмэлт тохиргоо, тусгай загвар шаардахгүйгээр бүх хүн ашиглахад тохиромжтой, энгийн бүтээгдэхүүн, программ, орчин болон үйлчилгээний хэв маягийг;¹¹

3.12. **“туслах хэрэгсэл”** гэж биеийн бүтцийн гажиг, үйл ажиллагааны алдагдлыг орлох, засах, хамгаалах, дэмжих, гэмтэл учрахаас урьдчилан сэргийлэх зориулалт бүхий хэрэгслийг;¹²

¹ НҮБ, Хүүхдийн Эрхийн Конвенц, 1990.

² Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 4.1.1.

³ Ахмад настны тухай хуулийн 3.1.

⁴ Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.9.

⁵ Хүүхдийн зуслангийн үйл ажиллагаа Ерөнхий шаардлага MNS 5633:2023

⁶ Хүүхдийн тоглоомын талбайн ерөнхий шаардлага MNS6751:2019.

⁷ Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 3.1.1.

⁸ Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3.1.8.

⁹ Төсвийн тухай хуулийн 4.1.21.

¹⁰ хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 4.1.3.

¹¹ хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 4.1.4.

¹² хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 4.1.8.

Дөрөв. Албан татварын хөнгөлөлт эдлэх төсөл, арга хэмжээ

4.1. Албан татварын хөнгөлөлт эдлэх төсөл, арга хэмжээ нь дараах төрөлтэй байна.

4.1.1.ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдэд зориулсан барилга байгууламж шинээр барих, өргөтгөх, шинэчлэх, засварлах;

4.1.2.ахмад настан, хагжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдэд зориулсан барилга байгууламж, зам, замын байгууламжид тохируулгат орчин бүрдүүлэх;

4.1.3.ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдэд зориулсан тоног төхөөрөмж, техник хэрэгсэл нийлүүлэх;

4.1.4.ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийн эрхийг хангах, хамгаалах чиглэлээр үзүүлсэн хандив, санхүүгийн дэмжлэг;

4.1.5.ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийн амрах, асруулах, сувилуулах, нийгэмшүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа ашгийн төлөө бус байгууллагын үзүүлж буй төлбөртэй болон төлбөргүй үйлчилгээ.

Тав. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийн төлөө зориулж хэрэгжүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагын татварын хөнгөлөлтөд хамруулах бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаанд тавигдах нийтлэг шаардлага

5.1.Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдэд зориулсан барилга байгууламж шинээр барих, өргөтгөх, шинэчлэх, засварлах арга хэмжээ нь дараах ерөнхий шаардлагыг хангасан байна.

5.1.1.ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийн хөгжил, хамгааллын талаарх төрийн болон салбарын бодлогод нийцсэн байх;

5.1.2.“Хөдөлмөрийн тухай хуулийн 145.4, 144.2, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 22.4 дэх хэсгийг тус тус биелүүлсэн байх;

5.1.3.тухайн орон нутгийн ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийн хөгжлийн хэрэгцээ шаардлагад нийцсэн байх;

5.1.4.бүтээн байгуулалтыг барьж, ашиглалтад орсоны дараа үйл ажиллагааг тогтвортой үргэлжлүүлэх, хүний нөөц, ашиглалттай холбоотой бусад зардлыг санхүүжүүлэх эх үүсвэртэй холбогдох судалгаа, тооцоотой байх;

5.1.5.бүтээн байгуулалтыг хэрэгжүүлсний дараа үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах шаардлагатай санхүүжилтийг хариуцан ажиллах байгууллага, албан тушаалтан тодорхой байх;

5.1.6.Барилгын тухай хуулийн 12, 13, 14, 15, 25, 26 дугаар зүйлд тусгасан шаардлагыг тус тус хангасан байх;

5.1.7.шинээр барьж байгуулах, засварлах, өргөтгөх, тохижилт хийх үйл ажиллагаа нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ шаардлага, онцлогт нийцсэн түгээмэл загвар бүхий зураг төсөлтэй байхаас гадна, тэгш хүртээмжтэй ашиглах боломжтой байх;

5.1.8. ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдэд үзүүлэх хандив, санхүүгийн дэмжлэг нь хувь хүний хэрэгцээ шаардлагад нийцсэн, бодит дэмжлэг үзүүлсэн байх;

5.1.9. авто замыг нэвтрэх явган хүний гарц, гүүрэн болон нүхэн гарц, явган зам болон барилга байгууламжид аюулгүй байдлыг хангасан урсдаг шат, цахилгаан шат, налуу шатыг нормын дагуу төлөвлөсөн байх;

5.1.10.барилга, байгууламжийн эдэлбэр газрын талбайд хамгийн багадаа хөгжлийн бэрхшээлтэй иргэний зорчих зам, тэдгээрийг тээвэрлэх, буулгах, авто зогсоолоос барилгын орц хүртэл аюулгүй хүрэх зам талбай, амралт чөлөөт цагаа өнгөрөөхөд зориулсан орон зай орчин, талбайг төлөвлөсөн байх;

5.1.11.барилга байгууламжийн эдэлбэр газарт эсвэл барилгын доторх нийт зогсоолын 10% (нэгээс доошгүй зогсоол)-ыг хөгжлийн бэрхшээлтэй иргэнд, түүний дотор тэргэнцэртэй иргэн бие дааж тээврийн хэрэгслийг ашиглах боломжтой байх;

5.1.12.зогсоол бүрт хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан тэмдэглэгээ мөн барилгын ойролцоо замын тэмдэг, барилгын доторх зогсоол руу нэвтрэх тэмдэг тэмдэглэгээнүүдийг барилгын хийцийн босоо элемент дээр (хана, багана, шон гэх мэт) 1.5 м -2.0 м-ийн өндөрт байрлуулсан байх;

5.1.13.хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг тээвэрлэхэд зориулсан цахилгаан шатны тоо, хэмжээ, шинж чанарыг сонгохдоо барилгад зорчих хөгжлийн бэрхшээлтэй иргэний хамгийн их тоо ба цахилгаан шатны жагсаалтыг тооцож төлөвлөсөн байх;

5.1.14.харааны бэрхшээлтэй иргэний аюулгүй байдлыг хангахад зориулж зорчигчдын урсдаг шат ба туузан замын захын хэсэгт аюулгүйн тоноглол хийсэн байх;

5.1.15.харааны бэрхшээлтэй худалдан авагчдад онцгойлон анхаарч хамгийн өргөн ашигладаг хөтөч зам, гэрлэн чиглүүлэгч, хүснэгтэн ба зурган бичээс, өнгөний ялгарал бүхий интерьерийн элементүүдийг төлөвлөлтөд тусгасан байх;

5.1.16.сургалт хүмүүжлийн ба олон нийтийн зориулалттай барилгын өрөө тасалгаанд харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан өнгөний ялгамжийг тодруулж өгсөн байх;

5.1.17.барилга байгууламж, зам талбай, цэцэрлэгт хүрээлэн бүтээн байгуулалтыг холбогдох мэргэжлийн байгууллагаар хянуулж дүгнэлт гаргуулсан байх;

5.1.18.хандив тусламжаар нийлүүлж буй тохижилт, тоног төхөөрөмж нь олон улсын стандартад нийцсэн, аюулгүй ажиллагааны шаардлага хангасан, орчин үеийн шинэ техник, технологид нийцсэн байх.

Зургаа.Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийн төлөө зориулж хэрэгжүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагын татварын хөнгөлөлтөд хамруулах бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаанд тавигдах тусгай шаардлага

6.1.Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдэд зориулсан барилга байгууламж шинээр барих, өргөтгөх, шинэчлэх, засварлах, тохижилт, тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлэх

6.1.1.ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийн төрөлжсөн асрамжийн газар, сэтгэцийн эмгэгтэй хүний асрамжийн газар шинээр барих, сэргээн засварлах, тохижилт, тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлэх;

6.1.2.нийтийн эзэмшлийн зам талбай барилга байгууламжид тулгуур эрхтний бэрхшээлтэй хүнд зориулсан боломжийг хангасан налуу зам, цахилгаан шат ба өргүүр хийх зэрэг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тохируулгат орчинг шинээр барьж байгуулах;

6.1.3.хүүхдэд зориулсан амрах, сувилуулах, асруулах нийгэмшихэд чиглэсэн хүүхдийн зуслан, хүүхдийн тоглоомын талбай, цэцэрлэгт хүрээлэн, хөгжлийн төв шинээр барих, сэргээн засварлах, тохижилт, тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлэх;

6.1.4.харааны бэрхшээлтэй хүнд зориулсан овгор, товгор байдлаар мэдрэгдэх тактелан зам, тэмтэрч мэдрэхэд зориулсан брайль үсгийг цахилгаан шат, шат, ариун цэврийн өрөөнд байршуулах;

6.1.5.хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд чиглэсэн хөгжлийн төв, урт хугацааны сэргээн засах төв, тасгийг барьж байгуулах, засварлах, тохижилт, тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлэх;

6.1.6.хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн дэргэд спорт заал барих, сэргээн засварлах, тохижилт, тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлэх;

6.1.7.ахмад настны идэвхтэй насжилтыг дэмжих төв, ахмадын ордон, өргөө, танхимын тоног төхөөрөмжийг шинэчлэх;

6.1.8.ердийн болон тусгай сургууль цэцэрлэгүүдэд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг суралцахад дэмжлэг үзүүлэх тохируулгат орчныг бүрдүүлэх, засварлах;

6.1.10.нийтийн тээврийн хэрэгслийг хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхдэд ээлтэй, хүртээмжтэй, аюулгүй байх тохируулга, засвар үйлчилгээг хийх; (дуут хөтөч, сонсголын бэрхшээлтэй хүнд унших дэлгэц, налуу зам г.м)

6.1.11.бүх төрлийн тэргэнцэр болон бусад дэмжих хэрэгслийг тохируулах, сэлбэх, засвар үйлчилгээ хийх.

6.2. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийн асрамжийн үйлчилгээ үзүүлэх, тэдгээрийн эрхийг хангах, хамгаалахад чиглэгдсэн хандив, санхүүгийн дэмжлэгт тавигдах тусгай шаардлага.

6.2.1.асрамж халамжийн төвд амьдарч буй хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, орон гэргүй ганц бие ахмад настныг орон сууцжуулах, орон сууцны түрээсийн зардлын дэмжлэг үзүүлэх;

6.2.2.хүүхдийн төлөө санд биет болон биет бус мөнгөн хөрөнгө хандивлах;

6.2.3.хөгжлийн бэрхшээлтэй хүн, асрамж халамжийн төвд амьдарч байгаа хүүхэд боловсрол эзэмшихэд дэмжлэг үзүүлэх, тэтгэлэг олгох, сургалтын төлбөрийг төлөх.

Долоо. Албан татварын хөнгөлөлт эдлүүлэх нийтлэг үйл ажиллагаа

7.1. Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй тохиолдолд татварын хөнгөлөлтийг тухайн тайлант хугацаанд татвар төлөгчийн төлсөн татвараас хөнгөлөх замаар эдлүүлнэ.

7.2.Татвар төлөгч нь Албан татвар төлөгчийн орлого олох үйл ажиллагаатай хамааралгүй бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагааг нийгмийн хариуцлагын хүрээнд дэмжих зорилгоор элэгдэл тооцох үндсэн хөрөнгөд оруулсан хөрөнгө оруулалт, харилцан хамааралгүй бусад этгээдэд олгосон санхүүгийн дэмжлэг, хандивын талаар тухайн орон нутаг, асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, хүлээн авсан байгууллагаас тодорхойлолт гаргуулсан байна.

7.3.Татвар төлөгч нь татварын хөнгөлөлт эдлэхдээ Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын салбарын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталсан шаардлагад нийцүүлэх бөгөөд шаардлагатай тохиолдолд нотлох баримтыг хавсаргана.

7.4.Татварын хөнгөлөлт эдлэхэд шаардагдах нэмэлт тодорхойлолт, баримтыг тухайн бүс орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа газар, хэлтэс гаргаж өгч болно.

Найм. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих

8.1.Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь Татварын ерөнхий газраас ирүүлсэн тайланг хуанлын 60 хоногийн дотор баталгаажуулан татварын албанд хөнгөлөлт эдлэх татвар төлөгчийн мэдээллийг хянаж хүргүүлнэ.